

Батлав. МУИС-ийн ХЭС-ийн  
захирал, проф.



*Д.Солонго*

Д.Солонго

**МУИС-ИЙН ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН АНГИ, ТАНХИМЫГ  
ХИЧЭЭЛИЙН БУС ЦАГААР АШИГЛУУЛАХ ЖУРАМ<sup>1</sup>**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү журам нь МУИС-ийн Хууль зүйн сургуулийн анги, танхимийг хичээлийн бус цагаар зүй зохицтой, зориулалтын дагуу ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тус сургуулийн анги, танхимыг багш, ажилтан, суралцагсдад (оюутан, магистрант, докторант) үнэ төлбөргүйгээр, харин бусдад гэрээний үндсэн дээр төлбөртэйгээр ашиглуулна. Төлбөрийн хэмжээг Захиргааны зөвлөл тогтооно.

1.3. Энэхүү журмын хэрэгжилтэнд сургуулийн захиргаа, Сургалтын алба, тэнхим, багш, Оюутны зөвлөл тус тус хяналт тавина.

**ХОЁР. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ:**

2.1. Тус сургуулийн анги, танхимыг багш, ажилтан, суралцагсад (цаашид үйлчлүүлэгч гэнэ) зөвхөн сургалт болон эрдэм шинжилгээний үйл ажиллагаа явуулах зорилгоор ашиглах эрхтэй.

2.2. Үйлчлүүлэгчийн иргэний цахим үнэмлэх, эсхүл оюутны үнэмлэхэд үндэслэн үйлчилнэ.

2.3. Үйлчлүүлэгч үйлчилгээний талаар санал бодлоо илэрхийлэх, хүсэлт гаргах эрхтэй.

2.4. Хууль зүйн сургуулийн Эрдмийн танхим, лекцийн өргөтгөл болон 101 тоот танхимыг ашиглах зөвшөөрлийг зөвхөн Сургалтын албаны эрхлэгч олгоно.

2.5. Бямба, Ням гараг, нийтээр амрах, баяр ёслолын өдрүүдэд 9-19 цагийн хооронд үйлчлүүлэхээр бол Сургалтын албанд бичгээр хүсэлт гаргаж зөвшөөрөл авна.

2.6. Нэгэн зэрэг хэд хэдэн анги, танхим ашиглах болон анги, танхимыг урт хугацаагаар ашиглах бол Сургалтын албаны эрхлэгчээс зөвшөөрөл авна.

2.7. Үйлчлүүлэгч харуул, хамгаалалтын ажилтнаас анги, танхимыг хүлээн авч, үйлчлүүлэх хугацаа дуусмагц цэвэрлэн, анхны байдалд оруулан хүлээлгэж өгнө.

<sup>1</sup> Захиргааны зөвлөлийн 2013 оны 9 дүгээр сарын 18-ний өдрийн хурлаар хэлэлцэж сайшаав

2.8. Үйлчлүүлэгч сургуулийн анги, танхимиын техник, хэрэгсэл, ширээ, сандал, цонх, хаалга, хана, бусад эд хогшилыг эвдэж гэмтээлгүй зүй зохистой ашиглана.

2.9. Үйлчлүүлэгч техник, хэрэгслийг солих, шилжүүлэх, сургуулиас авч гарах, бүрэн бүтэн байдлыг өөрчлөн оролдохыг хориглоно.

2.10. Үйлчлүүлэгч нь анги, танхимиийг ашиглах хугацаанд гадны хүн оруулах, согтууруулах ундаа, утаат тамхи хэрэглэх болон сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаанд харшлах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

2.11. Үйлчлүүлэгч энэ журмын 2.1-д зааснаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

#### **ГУРАВ. СУРГУУЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

3.1. Үйлчлүүлэгчтэй богино болон урт хугацааны үндсэн дээр анги танхим ашиглуулж болно.

3.2. Үйлчлүүлэгч энэ журмыг үл биелүүлэх тохиолдолд анги, танхимиyg чөлөөлж өгөхийг шаардах эрхтэй.

3.3. Үйлчлүүлэгчийн хүсэлтээр нэмэлт тоног, төхөөрөмжийг гаргаж өгч болно. Эдгээр тоног, төхөөрөмжийг ашиглахдаа энэхүү журмыг мөрдлөг болгоно.

#### **ДӨРӨВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА**

4.1. Үйлчлүүлэгч энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд анги, танхимаар үйлчлүүлэх эрхийг 1-3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.

4.2. Үйлчлүүлэгч анги, танхимиийн техник хэрэгсэл, бусад эд хогшлыг өөрийн буруугаас эвдэж, гэмтээсэн тохиолдолд учирсан хохирлыг бүрэн хариуцна.